



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: “Аймаг, нийслэлийн хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд, түүнчлэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах ”

**Аудит хийсэн
үндэслэл,
бүрэн эрх:**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэв.

АУДИТЫН ГОЛ ДҮГНЭЛТ: “БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА”

**Аудитын
тайланг
хүргүүлсэн:**

Аймгийн сонгуулийн хороонд хүргүүлсэн.

**Дархан-Уул аймаг
2024 оны 11 дугаар сар**

**Аудитын
зорилт**

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан ҮАГ, холбогдох байгууллагад танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- *Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулахад улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;*
- *Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх;*

**Аудитын
хамарсан
хүрээ**

Аудитад аймаг, сумдын сонгуулийн хороо, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газар зэрэг байгууллагуудыг хамруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр удирдаж, аудитын менежер У.Батсүрэн үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Б.Алтанзул, Э.Одгэрэл, Н.Отгонцэцэг нар гүйцэтгэсэн.

**Аудит хийхэд
гарсан
хүндрэл
бэрхшээл**

Аудитад хүндрэл бэрхшээл гараагүй болно.

НЭГ. СЕХ-НООС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ӨГСӨН ЗААВАР ЧИГЛЭЛИЙН ДАГУУ ТӨЛӨВЛӨСӨН Ч, СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООДОД ЗАРИМ ЗАРДЛЫГ ДУТУУ ХУВААРИЛСАН БАЙНА

Сонгууль зохион байгуулах зардлын төсвийг журамд заасны дагуу эдийн засгийн ангилал бүрээр төлөвлөжээ.

Дархан-Уул аймагт орон нутгийн 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах зардалд СЕХ-ны даргын 2024 оны А/68 дугаар тушаалаар 555.6 сая төгрөгийн төсөв баталсныг 6 удаагийн санхүүжилтээр бүрэн олгожээ. Зардлын эдийн засгийн ангиллыг СЕХ-ны 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.2¹-т заасны дагуу төлөвлөж, хуваарилсан байна.

СЕХ зардлын төсвийг төлөвлөхдөө аймаг, сумын сонгуулийн хороо, хэсгийн хороо, түүнд ажиллах ажилтнууд, мэдээллийн технологийн баг, даамлын тоогоор урамшуулал, хоолны зардлыг, унаа, бичиг хэрэг, шуудан холбоо, сургалт, сурталчилгааны болон бусад зардлыг эдийн засгийн ангилал бүрээр тооцож, төлөвлөжээ.

Аймгийн сонгуулийн хороо 3 төрлийн зардлыг СЕХ-ноос өгсөн зөвлөмж чиглэлийн дагуу хуваарилаагүй байна.

Аймаг, сумдын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор Дархан-Уул аймгийн сонгуулийн хороонд 21 төрлийн зардалд 555.6 сая төгрөг баталж, санхүүжүүлснээс 13.6 хувь буюу 75.5 сая төгрөгийг аймагт, 86.4 хувь буюу 480.1 сая төгрөгийг сумдын сонгуулийн хороонд тус тус хуваарилжээ.

СЕХ-ноос ирүүлсэн төсвийн зарцуулалтын тухай тайлбарт заасны дагуу төсөвт зардлыг хуваарилсан эсэхийг зардлын эдийн засгийн ангилал бүрээр давтан тооцоолоход:

- Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал 0.6 сая төгрөгийг аймаг, сумдын сонгуулийн хороонд хуваарилахдаа СЕХ-ны 2024 оны 3/777 дугаар албан бичгийн 1 дүгээр хавсралтын 1-т,
- Аймаг, сумын сонгуулийн болон хэсгийн хороонд олгох 35.9 сая төгрөгийг хуваарилахдаа аймгийн сонгуулийн хороонд 10.9 сая төгрөгийг хуваарилсан нь СЕХ-ны 2024 оны 3/834 дугаар албан бичгийн 1 дүгээр хавсралтын 3-т,
- Сурталчилгааны материал тараах унааны зардал 1.3 сая төгрөгийг аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан нь СЕХ-ны 2024 оны 3/909 дугаар албан бичгийн 1 дүгээр хавсралтын 2-т заасантай тус тус нийцэхгүй байна.

Аймгийн Цагдаагийн газар болон Улсын бүртгэлийн хэлтсийн сонгууль зохион байгуулах зардлын төсвийг төвлөрүүлэн захирагчаас хуваарилан олгожээ.

УБЕГ-ын даргын 2024 оны А/136 дугаар тушаалаар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст сонгогчийн бүртгэлийн тулган шалгах, бүртгэх, таньж оруулах, техник хэрэгсэл, программ хангамжийн хэвийн үйл ажиллагааг хангах зэрэг зардалд нийт 44.4 сая, Цагдаагийн ерөнхий газрын 2024 оны 16/3171 тоот албан

¹ Сонгуулийн Ерөнхий Хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст дараах зардлыг хуваарилна ...

бичгээр аймгийн Цагдаагийн газарт шатахуун, шуудан холбоо, албан хаагчийн хоол, хамгаалалтын зардалд нийт 44.3 сая төгрөгийг тус тус хуваарилсан байна.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, 4.5 сая төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

СЕХ-ноос аймгийн сонгуулийн хороонд Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах зардалд 555.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, гүйцэтгэлээр 551.1 сая төгрөг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 4.5 сая төгрөгийг СЕХ-ны 100900022001 тоот дансанд төвлөрүүлжээ.

Аудитаар сонгуулийн хороодын төсвийн зарцуулалтыг дансны хуулга, холбогдох анхан шатны баримтуудтай тулган шалгахад аймгийн сонгуулийн хорооны 2024 оны 07 дугаар захирамжаар сурталчилгааны зардлын 8.0 сая төгрөгийг аймгийн Мэдээлэл технологийн алба, орон нутгийн болон үндэсний телевиз, FM радиотой хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан ч гэрээний хэрэгжилтийг тооцоогүй байсныг аудитын явцад хэрэгжүүлж ажиллаа.

Мөн Хонгор сумын сонгуулийн хороо нь 5.5 сая төгрөгийн 16 ширхэг цахим төлбөрийн баримтыг харилцагч байгууллагуудаас гаргуулан аваагүй байсныг аудитын явцад залруулж, цахим төлбөрийн баримтыг гаргуулан ажиллаа.

Үүнээс бусдаар сонгуулийн зардлыг батлагдсан төсвийн дагуу зарцуулсан, нийт дүнгээр болон зардлын нэр төрлөөр хэтрээгүй, зүйл анги хооронд шилжүүлэн зарцуулаагүй байна.

Аймаг, сумдын сонгуулийн хороо батлагдсан төсвийн дагуу зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнажээ.

Аудитаар аймаг, сумдын сонгуулийн хорооны зардлын тайланг дансны хуулга, анхан шатны баримттай тулган шалгахад ажил, гүйлгээ тус бүрийн баримтыг хангалттай бүрдүүлж, зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнажээ.

Дархан-Уул аймгийн Цагдаагийн газар болон Улсын бүртгэлийн хэлтэс сонгуулийн зардлын тайланг хугацаанд нь дээд шатны байгууллагад тайлагнасан байв.

Аймгийн сонгуулийн хороо болон Санхүү, төрийн сангийн хэлтэс нь төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан байна.

Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 3.10²-т заасны дагуу аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороодын төсвийн хуваарилалтыг зардлын нэр төрөл бүрээр хүргүүлж, сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт тавьж ажиллажээ.

Аймаг, сумдын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь аймаг, сумдын сонгуулийн хорооны анхан шатны баримтад үндэслэн сонгуулийн зардлын зарцуулалтад хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

² Сонгуулийн ерөнхий хороо нь Төрийн сан болон орон нутгийн аудитын байгууллагаар дамжуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина.

ДҮГНЭЛТ:

- Аймгийн сонгуулийн хороо улсын төсвөөс олгосон санхүүжилтийг СЕХ-ноос өгсөн заавар, чиглэлийн дагуу тооцож төлөвлөсөн ч, сумдын сонгуулийн хороодод зарим зардлыг дутуу хуваарилсан байна.
- Сонгуулийн зардлыг батлагдсан төсвийн хуваарийн дагуу зарцуулжээ.
- Аймаг, сумдын сонгуулийн хороо нь “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын дагуу зардлын тайланг үнэн зөв, бодитой тайлагнажээ.